



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 сарын 23 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.55, 5.1.56 дахь заалт:

“5.1.55. Шүүх шинжилгээний тухай хуульд заасан зарим шүүх шинжилгээ хийх болон түүнд холбогдох үйлчилгээ үзүүлэх;

5.1.56. Шүүх шинжилгээний тухай хуульд заасан шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох.”

2/20 дугаар зүйлийн 20.1.6, 20.1.7 дахь заалт:

“20.1.6. Шүүх шинжилгээний тухай хуульд заасан шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 500 000-800 000 төгрөг;

20.1.7. энэ хуулийн 20.1.6-д заасан зөвшөөрлийн хугацааг сунгахад 400 000-600 000 төгрөг.”

3/20¹ дүгээр зүйл.

“20¹ дүгээр зүйл. Зарим шүүх шинжилгээ хийх болон түүнд холбогдох үйлчилгээг үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

20¹.1. Шүүх шинжилгээний байгууллагад хийгдэх дараах шүүх эмнэлгийн шинжилгээнд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

20¹.1.1. ДНХ-ээр эцэг, эх тогтоох лабораторийн шинжилгээ хийхэд 120 000-180 000 төгрөг;

20¹.1.2. хүний шээс, үс, хумс, шүлс, цусанд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис тодорхойлох лабораторийн шинжилгээ хийхэд 45 000-60 000 төгрөг;

20¹.1.3. лабораторид ДНХ-ийн аргаар хийх бактериологийн шинжилгээ хийхэд 15 000-20 000 төгрөг;

20¹.1.4. лабораторид бичил харуурын аргаар хийх бактериологийн шинжилгээ хийхэд 8 000-16 000 төгрөг;

20¹.1.5.лабораторид ийлдэс судлалын аргаар хийх бактериологийн шинжилгээ хийхэд 5 000-15 000 төгрөг;

20¹.1.6.хүний цусан дахь спиртийн агууламж тодорхойлох химийн шинжилгээ хийхэд 5 000-15 000 төгрөг;

20¹.1.7.хүний цусны бүлэг тогтоох лабораторийн шинжилгээ хийхэд 3 000-8 000 төгрөг;

20¹.1.8.гадаадын иргэн, харьяалалгүй хүний цогцост шүүх эмнэлгийн шинжилгээ хийхэд 800 000-1 000 000 төгрөг;

20¹.1.9.шарил дахин шинжлэх буюу эксгумацид хийхэд 300 000-500 000 төгрөг;

20¹.1.10.хэн болох нь тодорхойгүй цогцсыг оршуулсны дараа гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүнийх нь хүсэлтээр оршуулсан газраас гаргаж, хүлээлгэн өгөхөд 300 000-500 000 төгрөг;

20¹.1.11.эрүүл мэндийн даатгалаас төлөгдөх боломжгүй 18, түүнээс дээш настай байсан хүний цогцост шинжилгээ хийхэд 60 000-80 000 төгрөг;

20¹.1.12.иргэний хүсэлтээр цогцос хөргөгчид хадгалахад хоног тутамд 20 000-30 000 төгрөг, гурав хоногоос дээш хугацаагаар хадгалахад хоног тутамд 10 000-15 000 төгрөг;

20¹.1.13.цогцос зориулалтын машинаар тээвэрлэхэд километр тутамд 5 000 төгрөг.”

4/41 дүгээр зүйлийн 41.4.17-41.4.19 дэх заалт:

“41.4.17.хүний бэлгийн эрх, эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчид шүүх эмнэлгийн шинжилгээ хийхэд;

41.4.18.амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэнд шүүх шинжилгээ хийхэд;

41.4.19.18 насанд хүрээгүй хүний шүүх шинжилгээг хийхэд.”

2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “14-20 дугаар зүйл” гэснийг “14, 15, 16, 17, 18, 19, 20, 20¹ дүгээр зүйл” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР